



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА
М.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлсийн талаар тодруулахад үндсэн хөрөнгийн данс 117.3 сая төгрөгөөр нэмэгдсэний дийлэнх хувийг тээврийн хэрэгслийн данс эзэлж байгаа нь орон нутгийн төсвөөс тэврийн хэрэгсэл худалдан авч өгснийг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Мөн цалингийн зардал өмнөх оноос 403.0 сая төгрөгөөр буюу 66.5 хувиар өссөн нь дараах шалтгаануудтай холбоотой байна. Үүнд:

- Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг нэмсэн;
- Албан хаагч нарт Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу улирал бүр, Сангийн сайдын 2020 оны 33 дугаар тушаалын дагуу сар, тайлант оны эцэст Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар төсвийн үлдэгдлээс 53.0 сая төгрөгийн урамшууллыг олгосон;
- Цалингийн зардлаас ахмадын санд 33.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын

4825020172

өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон дараах асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байна. Үүнд: Албан хаагчдад Сангийн сайдын 2020 оны 33 дугаар тушаалын дагуу сар бүр мөнгөн урамшил, Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалыг үндэслэн оны эцэст үндсэн цалин, нэмэгдэл цалинтай тэнцүү хэмжээний мөнгөн урамшил олгосон нь Засгийн газрын 2019 оны 5-р тогтоолтой зөрчилдөж байгаа талаар дүгнэлт гарах шаардлагатай гэж үзлээ

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын удирдлага жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 13 зорилт, 47 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 99.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	118,462,602.90	122,072,734.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,709,478.15	35,598,709.15
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	28,709,478.15	35,598,709.15
31211	Төрийн сангийн харилцах	28,709,478.15	35,598,709.15
33	АВЛАГА	3,710,493.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,710,493.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,710,493.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,042,631.75	86,474,025.09
354	Хангамжийн материал	86,042,631.75	86,474,025.09
35410	Бичиг хэргийн материал	5,381,900.00	5,204,960.00
35420	Аж ахуйн материал	6,295,775.00	4,828,808.34
35430	Сэлбэг хэрэгсэл	14,500.00	802,100.00
35440	Түлш, шатах тослох материал	400,000.00	835,000.00
35470	Бусад хангамжийн материал	73,950,456.75	74,803,156.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	169,447,635.10	250,676,367.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	169,447,635.10	250,676,367.59
392	Биет хөрөнгө	162,367,635.10	243,596,367.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	42,997,469.00	42,997,469.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,151,774.33	-6,247,860.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,900,000.00	166,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,421,026.47	-57,591,372.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,631,819.13	240,480,819.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		121,678,053.39	145,523,889.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,141,954.00	23,133,954.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,052,752.84	-20,052,752.84
393	Биет бус хөрөнгө	7,080,000.00	7,080,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,080,000.00	7,080,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	287,910,238.00	372,749,101.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	244,000.00	1,464,068.00
413	Өглөг	244,000.00	1,464,068.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,464,068.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	244,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	287,666,238.00	371,285,033.83
51	Засгийн газрын хувь оролцоо	287,666,238.00	371,285,033.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	165,159,465.00	165,159,465.00
51101	Өмч: - төрийн	165,159,465.00	165,159,465.00
512	Хуримтлагдсан үр дүн	111,308,505.37	194,927,301.20
51210	Өмнөх үеийн үр дүн	170,902,417.15	115,200,555.37
51220	Тайлант үеийн үр дүн	-59,593,911.78	79,726,745.83
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,198,267.63	11,198,267.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	287,910,238.00	372,749,101.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,235,262,346.00	1,773,007,418.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	37,860,471.60	147,779,731.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,650,000.00	3,388,731.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,650,000.00	33,388,731.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,210,471.60	114,391,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,197,401,875.00	1,625,227,687.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,177,739,500.00	1,566,126,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,177,739,500.00	1,566,126,100.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,662,375.00	59,101,587.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,662,375.00	59,101,587.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,294,856,258.38	1,693,280,672.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,294,856,258.38	1,693,280,672.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,928,709.59	1,517,314,127.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,404,818.00	1,203,443,811.00
210101	Үндсэн цалин	397,070,770.00	525,058,647.00
210102	Нэмэгдэл	198,833,681.00	444,447,782.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,032,000.00	48,373,091.00
210104	Урамшуулал	166,468,367.00	185,564,291.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,674,654.00	144,997,506.00
210201	Тэтгэврийн даатгал	66,599,397.42	100,508,711.94
210202	Тэтгэмжийн даатгал	8,961,022.73	10,984,993.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,182,077.78	5,798,667.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,285.95	5,541,026.32
210205	Эрүүл мэндийн даатгал	15,392,870.12	22,164,107.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,842,736.57	14,930,644.45
210301	Гэрэл, цахилгаан	2,093,106.57	2,790,269.45
210302	Түлш, халаалт	10,069,170.00	11,306,295.00
210303	Цэвэр, бохир ус	680,460.00	834,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,426,698.58	23,229,632.08
210401	Бичиг хэрэг	6,255,960.00	6,358,140.00
210402	Тээвэр, шатахуун	5,359,220.00	5,846,049.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,179,683.58	2,490,956.42
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	82,560.00	48,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,549,275.00	8,486,486.66
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,326,050.00	10,668,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,462,500.00
210604	Урсгал засвар	5,326,050.00	9,206,350.00
2107	Томилолт, зочны зардал	5,096,000.00	7,028,000.00
210702	Дотоод албан томилолт	5,096,000.00	7,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,369,826.06	46,285,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,102,500.06	45,490,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	369,200.00	369,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,426.00	50,866.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	92,700.00	352,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,787,926.38	66,730,667.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,500,000.00	26,999,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,377,000.00	3,618,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	91,910,926.38	36,112,267.51
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,927,548.79	175,966,545.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,750,000.00	168,259,398.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	50,661,184.77
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	114,958,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,640,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	197,177,548.79	7,707,146.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,177,548.79	7,707,146.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-59,593,911.78	79,726,745.83
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-59,593,911.78	79,726,745.83
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-59,593,911.78	79,726,745.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,226,051,875.00</u>	<u>1,658,616,418.50</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,650,000.00	33,388,731.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,650,000.00	33,388,731.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,650,000.00	33,388,731.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,650,000.00	33,388,731.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,197,401,875.00	1,625,227,687.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,177,739,500.00	1,566,126,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,177,739,500.00	1,566,126,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,662,375.00	59,101,587.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,662,375.00	59,101,587.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,213,601,875.00</u>	<u>1,648,735,187.50</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,213,601,875.00	1,648,735,187.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,013,674,326.21	1,472,768,642.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,871,311.00	1,191,933,107.00
210101	Үндсэн цалин	413,439,406.00	525,232,818.00
210102	Нэмэгдэл	182,937,708.00	398,611,378.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,424,057.00	47,995,091.00
210104	Урамшуулал	168,199,631.00	220,093,820.00
210105	Гэрээт ажлын хөлс	870,509.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,674,654.00	147,685,599.50
210201	Тэтгэврийн даатгал	66,599,397.57	102,771,104.94
210202	Тэтгэмжийн даатгал	8,961,022.93	11,410,693.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,182,077.54	5,798,667.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,285.39	5,541,026.32
210205	Эрүүл мэндийн даатгал	15,392,870.57	22,164,107.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,842,736.57	14,930,644.45
210301	Гэрэл, цахилгаан	2,093,106.57	2,790,269.45
210302	Түлш, халаалт	10,069,170.00	11,306,295.00
210303	Цэвэр, бохир ус	680,460.00	834,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,537,348.64	19,715,525.42
210401	Бичиг хэрэг	4,045,560.00	6,900,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,359,220.00	6,281,049.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,179,683.64	2,490,956.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	82,560.00	48,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,870,325.00	3,995,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,863,550.00	14,401,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,408,000.00
210604	Урсгал засвар	5,863,550.00	9,993,950.00
2107	Томилолт, зочны зардал	5,096,000.00	7,028,000.00
210702	Дотоод албан томилолт	5,096,000.00	7,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,782,926.00	46,285,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,515,600.00	45,490,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	369,200.00	369,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,426.00	50,866.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	92,700.00	352,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,005,800.00	30,788,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,500,000.00	26,999,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,505,800.00	3,789,300.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,927,548.79	175,966,545.13

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,750,000.00	168,259,398.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	50,661,184.77
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	114,958,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,640,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	197,177,548.79	7,707,146.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,177,548.79	7,707,146.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,450,000.00</u>	<u>9,881,231.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>00.00</u>	<u>2,992,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>00.00</u>	<u>2,992,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,992,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	-2,992,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	<u>-2,992,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>12,450,000.00</u>	<u>6,889,231.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,450,000.00	6,889,231.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,259,478.15	28,709,478.15
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,709,478.15	35,598,709.15

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,159,465.00	11,198,267.63	170,902,417.15	347,260,149.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	165,159,465.00	11,198,267.63	170,902,417.15	347,260,149.78
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-59,593,911.78	-59,593,911.78
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,159,465.00	11,198,267.63	111,308,505.37	287,666,238.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,159,465.00	11,198,267.63	111,308,505.37	287,666,238.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	165,159,465.00	11,198,267.63	111,308,505.37	287,666,238.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	79,726,745.83	79,726,745.83
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,159,465.00	11,198,267.63	194,927,301.20	371,285,033.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,566,126,100.00	1,558,418,953.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,566,126,100.00	1,558,418,953.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,397,866,600.00	1,390,159,554.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,143,413,100.00	1,140,031,021.00
210101	Үндсэн цалин	500,057,700.00	525,232,818.00
210102	Нэмэгдэл	320,364,800.00	346,709,292.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,908,700.00	47,995,091.00
210104	Урамшуулал	266,081,900.00	220,093,820.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,926,500.00	140,986,098.00
210201	Тэтгэврийн даатгал	98,408,300.00	96,071,603.44
210202	Тэтгэмжийн даатгал	11,129,500.00	11,410,693.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,564,700.00	5,798,667.22
210204	Ажилгүйдлийн даатгал	5,564,800.00	5,541,026.32
210205	Эрүүл мэндийн даатгал	22,259,200.00	22,164,107.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,313,200.00	14,930,644.45
210301	Гэрэл, цахилгаан	2,801,100.00	2,790,269.45
210302	Түлш, халаалт	11,306,300.00	11,306,295.00
210303	Цэвэр, бохир ус	1,205,800.00	834,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,896,000.00	20,515,525.42
210401	Бичиг хэрэг	6,900,000.00	6,900,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,600,000.00	6,281,049.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	2,490,956.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	48,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,400,000.00	4,795,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,600,000.00	16,593,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,600,000.00	6,600,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,993,950.00
2107	Томилолт, зочны зардал	7,420,000.00	7,028,000.00
210702	Дотоод албан томилолт	7,420,000.00	7,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,507,800.00	46,285,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,692,000.00	45,490,250.00
210803	Даатгалын үйлчилгээ	369,200.00	369,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,900.00	50,866.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	352,700.00	352,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,790,000.00	3,789,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,790,000.00	3,789,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,259,500.00	168,259,398.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	168,259,500.00	168,259,398.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,661,200.00	50,661,184.84
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	114,958,300.00	114,958,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	2,640,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,566,126,100.00	1,566,126,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,566,126,100.00	1,566,126,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,566,126,100.00	1,566,126,100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,101,587.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,101,587.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,101,587.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,902,086.00
210102	Нэмэгдэл	5,190,086.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,699,501.50
210201	Тэтгэврийн даатгал	6,699,501.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,101,587.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,101,587.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,101,587.50
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **20,581.1** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч аудитын явцад **10,493.0** мянган төгрөгийн 3 алдааг залруулж, **10,088.1** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт **10,493.0** мянган төгрөгийн алдаа¹ илрүүлснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тайлан онд үүссэн хувь хүний орлогын албан татварын 1,464.1 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнаагүй;
2. Үр дүн тайланд цалингийн зардлыг дутуу, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 6,036.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
3. Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 2,992.0 мянган төгрөгийн зардлыг тайлагнаагүй.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/ 20.2.4-д /Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"/ заасныг зөрчиж мөн Иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 10,088.1 мянган төгрөгийн залруулагдах боломжгүй зөрчил илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал **2,688.1** мянган төгрөгийг цалингийн зардлаас төлж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16 дугаар зүйлийн 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ заасныг тус тус зөрчиж үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс **2,992.0** мянган төгрөгөөр тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38 дүгээр зүйлийн 38.1-т /*Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна*/, 38.5-д /*Цахим дэлгүүрт нэг гүйцэтгэгч байгаа, эсхүл үнийн санал дуудахад үнийн санал ирээгүй бол захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн хамгийн бага үнийн санал бүхий бараа, үйлчилгээг худалдан авч*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

болно/, Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4-т /Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/ заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Багаж техник хэрэгслийн зардлаас анхан шатны баримтаар тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн нэхэмжлэл, орлого зарлагын баримтыг үндэслэн ажил гүйлгээ хийсэн боловч хөрөнгийг орлогод тусгахдаа эргэлтийн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг авч анхан шатны баримтаас зөрүүтэй худалдан авалт хийж **4,408.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.6 /анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.1.4-т /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажсаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх/ заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлан онд үүссэн хувь хүний орлогын албан татварын өр төлбөрийг тайлагнаагүй.	1	1,464.1	1	1,464.1			1	1,464.1				
Үр дүн тайланд цалингийн зардлыг дутуу, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг илүү тайлагнасан.	1	6,036.9			1	6,036.9	1	6,036.9				
Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг хөрөнгийн зардалд тайлагнаагүй.	1	2,992.0			1	2,992.0	1	2,992.0				
Дүн	3	10,493.0	1	1,464.1	2	9,029.9	3	10,493.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас зардлаас төлж батлагдсан эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	2,688.1			1	2,688.1						
Багаж техник хэрэгслийн зардлаас нэхэмжлэхийн дагуу тоног төхөөрөмжийн үнийг шилжүүлсэн боловч анхан шатны баримтаас зөрүүтэй бараа материал хүлээн авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	4,408.0			1	4,408.0						
Нийт дүн	2	7,096.1	-	-	2	7096.1	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан..	1	2,992.0			1	2,992.0							
Дүн	1	2,992.0			1	2,992.0							
Нийт дүн	1	2,992.0			1	2,992.0	-	-	-	-	-	-	-